МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 28

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛЫН ТАЛААР УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Нийслэлийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсээс Хяналт, үнэлгээний үндэсний хороо болон яам, агентлагийн хяналтын газрын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгууллаа.

Монгол Улсын засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 07 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний үндэсний хороог байгуулсан бөгөөд хяналт шалгалтын үйл ажиллагааны уялдааг хангах, салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах талаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулах зэрэг чиг үүрэгтэй.

Прокуророос зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудлын талаар санал солилцлоо.

Уулзалтын үр дүнд хамтын ажиллагааг сайжруулах, салбарын хяналтыг хэрэгжүүлж буй эрх бүхий албан тушаалтнуудын хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтарсан зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үе шаттай арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1096